

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12/09 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 13/15 дугаар тогтоолоор 101 төсөл, арга хэмжээний 31.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсаны дагуу аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2020 оны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Бусад эх үүсвэрээр санхүүжигдах болон харьяа агентлагийн санал хүсэлтийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 858,2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ төлөвлөгөөнд нэмэгдсэн.


Тухайн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвөөс 7,3 тэрбум төгрөгийн 17 ажлын эрх шилжиж ирсэн. Үүнд: Боловсрол, соёл шинжлэх ухааны яамнаас 5,3 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 1,8 тэрбум төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, Эрүүл мэндийн яамнаас 151,9 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирснээс 17 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 6,9 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан.

Захиалагчаар батлуулсан 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 39,5 тэрбум төгрөгийн 125 төсөл арга хэмжээ тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар 120 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулан 115 төсөл, арга хэмжээний 32,7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна. Нийт төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-с 3 ТАХ санхүүжилтийн хүндрэлтэй нөхцөл байдал үүдсэнээс төлөвлөгөөнөөс хасагдах захиалагчийн шийдвэр гарсан. Төлөвлөгөөний гүйцэтгэл 98,3 хувь



Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагаас 6 байгууллага 2020 оны жилийн эцсийн байдлаар 19 төсөл арга, хэмжээний төсөл, арга хэмжээний 3,8 тэрбум төгрөг тусгагдсанаас 2,5 тэрбум төгрөгийн 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан ажлыг графикаар үзүүлбэл



Аймгийн харьяа агентлаг болон ОНХС, ОНТХО, ЗС, бусад эх үүсвэрээс санхүүжих 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 43,3 тэрбум төгрөгийн 144 төсөл арга хэмжээ тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар 130 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулан 35,3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан, төлөвлөгөөнд тусгагдсан 23 төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлж төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

Аймгийн 14 сумдын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2020 оны төлөвлөгөөнд 7,7 тэрбум төгрөгийн 155 тендер шалгаруулалт тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар 6,7 тэрбум төгрөгийн 128 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулан 6,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. 14 сумдын төсөвт байгууллагын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 7 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ хүлээгдэж байна, 16 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж тендер нээх болон гэрээ байгуулах хуулийн хугацааг хүлээж байна.

Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 14/04 дугаар тогтоолоор 4 төсөл арга хэмжээг сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хасагдсан байна.

Сумдын харьяа байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2020 оны төлөвлөгөөнд 3,4 тэрбум төгрөгийн 39 тендер шалгаруулалт тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар 1,9 тэрбум төгрөгийн 27 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулан гэрээ байгуулсан.

Нийт Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны төлөвлөгөөнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 54,5 тэрбум төгрөгийн 338 тендер шалгаруулалт тусгагдсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 285 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулан 45,1 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

Санхүүжилтын эх үүсвэрээр



1.2 2020 оны жилийн эцсийн байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийн 5,3 тэрбум төгрөгийн 17 ажлын захиалагчийн эрх яамдаас шилжин ирж 17 төсөл арга хэмжээний 6,9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнд:

1. ЭМЯ/202001074 Төмөр замын эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 4 дүгээр баг/

2. ЭМЯ/202001076 Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 2 дугаар баг/

3. БСШУСЯ/202001355 “Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр /Дорноговь, Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/

4. БСШУСЯ/202001098 Сургуулийн барилгын гадна фасад, дээврийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 5 дугаар сургууль/

5. БСШУСЯ/202001291 Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Дорноговь, Замын-Үүд сум/

6. БСШУСЯ/202001140 Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорноговь, Иххэт сум/

7. БСШУСЯ/202001068 Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 1, 2, 5 дугаар сургууль/

8. БСШУСЯ/202001158 Цэцэрлэгийн дотор хаалга, заслын ажил /Дорноговь, Сайншанд сум, 6 дугаар цэцэрлэг/

9. ХНХЯ/202002006 Хүүхдийн ордны барилгын их засвар /Дорноговь, Сайншанд сум/

10. БСШУСЯ/202001141 Цэцэрлэгийн барилгын их засвар /Дорноговь, Сайншанд сум, 1 дүгээр цэцэрлэг/

11. ХНХЯ/202002004 Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/

12. БСШУСЯ/202002522 Кино театрт тавилга, тоног төхөөрөмж худалдан авах /Дорноговь, Сайншанд сум/


13. БСШУСЯ/202001106 Сургуулийн барилгын их засвар /Дорноговь, Хатанбулаг сум/

14. БСШУСЯ/202001105 Сургуулийн барилгын их засвар /Дорноговь, Өргөн сум/

15. БСШУСЯ/202001134 Сургуулийн хичээлийн байрын их засвар /Дорноговь, Дэлгэрэх сум/

16. БСШУСЯ/202001134 Хатанбулаг сумын соёл спортын төвийн дуусгал ажил

17. БСШУСЯ/202001105 Сайншанд сумын 13-р цэцэрлэгийн тавилга, эд хогшил худалдан авах



1.3 2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 3 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалт захиалагчаас ирүүлсэн нөхцөл байдлын улмаас хасагдаж тендер шалгаруулалт хүчингүй болсон. зарлагдаагүй, /Захиалагчаас ирүүлсэн албан бичгийг хавсаргав/ 1 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ хүлээгдэж байна. Техникийн тодорхойлолт, ажлын даалгаварыг холбогдох албан газарт боловсруулан бэлтгэж байна.

Харьяа агентлаг, байгууллагаас 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ хүлээгдэж байна.

14 сумдын төсөвт байгууллагын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 7 төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ хүлээгдэж байна.

1.5 Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт зохион байгуулахдаа хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв, бодитой төлөвлөж, хэрэгжилтийг хангаж, тайлагнах, үр ашигтай явуулахыг мөрдлөг болгон ажилласан. Тендер шалгаруулалт зохион байгуулах явцад гарсан зөрчил дутагдал байхгүй.

1.6 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд 4 гомдол гарсан. Үүнд:

2020 ОНД ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРААС ГАРГАСАН ГОМДЛЫН МЭДЭЭЛЭЛ

12/1/2020

№	Төсөл арга хэмжээний нэр /Багцын дугаар/	Гомдол гаргасан оролцогчийн нэр	Хаана гомдол гаргасан /Захналагч, ШӨХТГ, Сангийн яам, Шүүх г.м/	Гомдлыг хансан шийдвэрийн утга /дахин үнэлгээ хийх, хүчингүй болох г.м/	Шийдвэрийг хэрэгжүүлсэн байдал	Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулагдсан эсэх	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсвөөс хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ							
Ажил							
1	Сургуулийн барилгын гадна фасад, дээрийн засвар /Дорноговь, Сайншанд сум, 5 дугаар сургууль/	"Цагаан Удам" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	Дахин үнэлгээг хийж тендер шалгаруулалтын үр дүнг өөрчилсөн	Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулсан	2020/04/06-ны өдрийн 6-1/2161 2020/04/16-ны өдрийн 6-1/2470
2	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дорноговь, Сайншанд сум, 2 дугаар баг/	"Мехотроник" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу дахин үнэлгээ хийж тендер шалгаруулалтын шийдвэр хэвээр үлдсэн.	Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулсан	2020/04/23-ны өдрийн 6-1/2675, 2020/04/24-ний өдрийн 164, 2020/04/30-ны өдрийн 6-1/2910
3	Дорноговь аймгийн Сайншанд сумын Нэгдсэн эмнэлгийн засвар	"Гларий монголиа" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу дахин үнэлгээ хийж тендер шалгаруулалтын шийдвэр хэвээр үлдсэн.	Дахин зарласан.	2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 6-1/6783 ,2020/11/03-ны өдрийн 6-1/6955
4	Хүүхдийн зуслан байгуулах	"Сизу" ХХК	Сангийн яам	Дахин үнэлгээ хийх	Дахин үнэлгээг хийж тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон.	Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулсан	2020/08/18-ны өдрийн 6-1/5440 2020/08/26-ны өдрийн 6-1/5612



1.7 Аймгийн 2020 оны жилийн эцсийн байдлаар зарлагдсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу 47 аж ахуйн нэгжүүдээс орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах, дотоодод үйлдвэрлэсэн бараа материал худалдан авах хүсэлт ирж, нотлох баримтуудыг үндэслэн дотоодын давуу эрхийн зөрүүг 1,3 тэрбум төгрөгөөр хийсвэрлэн тооцсон. Дотоодын үйлдвэрлэгчийг дэмжиж бодлогын хүрээнд дотоод үйлдвэрлэсэн 4 нэр төрлийн морин хуурийг нийлүүлэхээр 24,4 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.

Сумдын 2020 оны жилийн эцсийн байдлаар зарлагдсан төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрх олгохоор тусгагдсаны дагуу дотоодын үйлдвэрлэгчийг дэмжиж бодлогын хүрээнд дотоодод үйлдвэрлэсэн давхардсан тоогоор 1000 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхээр 581,0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.

Хоёр. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР

2.1 Аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 258 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 100 хувь хялбаршуулсан цахим системээр зохион байгуулсан.

Тендер шалгаруулалтын үр дүнг тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журмын дагуу цахим систем нийтэлж журмыг хэрэгжүүлэн ажилласан.



2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээ байхгүй болно.

2.3 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу зохион байгуулагдсан тендер шалгаруулалт байхгүй болно.

Гурав. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ ТАЛААР

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагаас 6 байгууллага 2020 оны хагас жилээр 19 төсөл арга, хэмжээний 3,8 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулан 2,5 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаанд Орон нутгийн өмчийн газраас зааварчилгаа, аргачлалаар ханган ажилласан.

2020 оны жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд гишүүнээр ажиллаж, цахим худалдан авах ажиллагааны сургалт, мэдээлэл, зааварчилгаа, аргачлалаар хангаж ажилласан.

Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Орон нутгийн өмчийн газартай хамтран орон нутагт бүртгэлтэй авто зам, барилгын угсралтын тусгай зөвшөөрөлтэй 20 ахуйн нэгж, байгууллагад 2017-2020 онд хийж хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайлан мэдээг танилцуулж, тендер оролцогчдоос цахим тендер илгээхэд гаргасан алдаа дутагдалд заавар, зөвлөмж өгөх сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа.



Сургалтаар ААН, байгууллагад тулгамдаж буй асуудлын талаар санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх талаар холбогдох байгууллагад үүрэг чиглэл өгч ажиллах шийдвэр гаргасан.



Сайншанд сумын ЗДТГ-аас аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үдийн цай, цэцэрлэгүүдийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх үнэлгээний хорооны гишүүдэд 2020.10.28-ны өдөр Тендерийн баримт бичгийн бүрдүүлэлт, үнэлгээний хорооны ажиллах журмын талаар сургалт зохион байгуулсан.

Үнэлгээний хорооны гишүүд нь зөвлөн туслах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахад хяналт

тавих чиг үүрэгтэй ажилласан.

Аймгийн 14 сумдын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2020 оны төлөвлөгөөнд 7,7 тэрбум төгрөгийн 155 тендер шалгаруулалт тусгагдсанаас жилийн эцсийн байдлаар 6,7 тэрбум төгрөгийн 128 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулан 6,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан.

Сумдын худалдан авах ажиллагааг графикаар үзүүлбэл



Төсвийн ерөнхийлөн захирагчаас захиалагчийн эрх шилжүүлсэн ТАХ, төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-ний худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Үүнд:

1. “Чандмань Илч” ОНӨ ХХК
2. “Сайншанд сумын ЗДТГ”-т эрх шилжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагаанд явцын хяналт, зөвлөн туслах
3. “Сайншанд сумын Зүүн баян багийн ЕБС, Сайншанд сумын 12, 4, 6 дугаар цэцэрлэгт худалдан авах ажиллагааны хэрэгжилт
4. Айраг, Даланжаргалан, Хөвсгөл сумдын 2019 оны ХАА-ны хэрэгжилтэд хяналт шалгалтыг хийсэн. ОНӨГ-ын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалт цар тахал ковид-19 өвчний хөл хорионоос шалтгаалан зогссон.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллага, сумдад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ ЧИГЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, захиалагчийн эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний төсвийг нягтлан шалгаж, магадалсны үндсэн дээр худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2020 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулж, төсөл арга хэмжээний ажлыг эхлүүлсэн байх.

2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний явцад илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийж, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байхад онцгой анхаарч, худалдан авах

ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайланд тусган нэгтгэж гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллах.

3. 2020 онд худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар /tender.gov.mn/ зарлах

4. Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журмын дагуу 2020 оны худалдан авах ажиллагааны үр дүнг гарсан өдөрт нь мэдээллийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулах, гэрээний хэрэгжилтийг бүрэн оруулах

5. 2020 оны худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулсан ажлын гэрээ байгуулсан үндэслэл, гэрээ, хуулийн этгээдийн материалын хувийг Орон нутгийн өмчийн газарт 2 хувь ирүүлэх.

6. Захиалагч байгууллагууд Төрийн цахим худалдан авах ажиллагааны системийн хөтлөлтөд анхаарч, холбогдох мэдээллийг бүрэн оруулах

7. Худалдан авах ажиллагааны сарын тайланг сар бүрийн 25-ны дотор, хагас жилийн тайланг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, жилийн эцсийн тайланг 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө Сангийн сайдын 2018 оны 281 тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу цахимаар болон цаасаар баталгаажуулан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг баримтлан байгууллагын эдийн засгийн ангиллаар тендер шалгаруулалтыг зарлах

9. Дээрх өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлээгүй тендер шалгаруулалтыг заагдсан хугацаанд зохион байгуулаагүй албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцохыг анхааруулья.

10. Худалдан авах ажиллагааг 2020 оны багтаан зохион байгуулаагүй, төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохгүй болохыг мэдэгдье.


11. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдлөг болгон ажиллахыг хүсье.

Дөрөв. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ, САНАЛ

4.1 Нийт Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны төлөвлөгөөнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны 54,5 тэрбум төгрөгийн 338 тендер шалгаруулалт тусгагдсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 285 тендер шалгаруулалт амжилттай зохион байгуулан 45,1 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

Ил тод байдал: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн албан хаагч, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажилласан. Худалдан авах ажиллагааг хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж зарлагдсан тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, www.dornogovi.gov.mn, аймгийн Орон нутгийн өмчийн газар, цахим

хуудаст байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг тендер зарлагдсан өдөрт нь өдөр тутмын сонинд нийтлүүлсэн. Мөн тендер шалгаруулалтын явцад гарсан үр дүнг тухай бүрт нь байгууллагын мэдээллийн самбар болон www.shilendans.gov.mn, www.dornogovi.gov.mn, аймгийн Орон нутгийн өмчийн газар, Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудасад худалдан авах ажиллагааны хэрэгжилт явцын талаар мэдээлэл хийж олон нийтэд хүргэж ажиллаа.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн албан хаагч, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажилласан.

4.2 2020 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын гэрээний хэрэгжилт Аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас барилга угсралт, их засварын ажлын явцад захиалагчийн хяналтыг гэрээ байгуулан хэрэгжүүлж, үе шатны хяналтыг тавьж, ил далд ажлыг фото зургаар баталгаажуулж, актаар баталгаажуулан, гүйцэтгэлийн дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажиллаж байна.

Гүйцэтгэлийн дугаар:	393,816,079 ₮	Гүйцэтгэгч рүү илгээсэн
2020-10 21 Сайншанд суманд 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажил Захиалагчийн нэр: Дорноговь аймгийн орон нутгийн өмчийн газар Гүйцэтгэгч байгууллага: 4,968,888,888 ₮	Гүйцэтгэгч рүү илгээсэн	Гэрээний дугаар ДГАОНӨГ/202012002 Дуусах огноо 2021-08-20
2020-09 10 Сайншанд суманд халдвартын эмнэлгийн барилга барих ажил Захиалагчийн нэр: Дорноговь аймгийн орон нутгийн өмчийн газар Гүйцэтгэгч байгууллага: 2,181,306,006 ₮	Зөвшөөрсөн	Гэрээний дугаар ДГАОНӨГ/202012001 Дуусах огноо 2021-07-01
2020-09 07 Сайншанд сумын 12-р цэцэрлэгийн дээврийн засварын ажил Захиалагчийн нэр: Дорноговь аймгийн орон нутгийн өмчийн газар Гүйцэтгэгч байгууллага: 12,795,755 ₮	Зөвшөөрсөн	Гэрээний дугаар ДГАОНӨГ/202012032 Дуусах огноо 2020-09-15
2020-09 04 Хүүхдийн зуслан байгуулах /Дорноговь/ Захиалагчийн нэр: Дорноговь аймгийн орон нутгийн өмчийн газар Гүйцэтгэгч байгууллага: 1,589,691,101 ₮	Гүйцэтгэгч рүү илгээсэн	Гэрээний дугаар ХНХЛ/202002004 Дуусах огноо 2021-08-10
2020-08 26 Алтанширээ сумын тойг, хаяа багийн төвийн барилгын өргөтгөл хийх ажил /2*60000.0/ Захиалагчийн нэр: Дорноговь аймгийн орон нутгийн өмчийн газар Гүйцэтгэгч байгууллага: 11,4967,212 ₮	Гүйцэтгэгч рүү илгээсэн	Гэрээний дугаар ДГАОНӨГ/202012036 Дуусах огноо 2020-10-30

4.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг талаарх хүсэлт
Хууль эрх зүйн орчныг сайжруулах санал:

- Хуулийн 21 дүгээр зүйлийн 1-т захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасан нь цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулагддаг болсонтой холбоотойгоор

сонин хэвлэлд заавал нийтлэх хуулийн заалтыг хасах. Учир нь өдөр тутмын сонин хэвлэлийн зах зээлийн үнэ ханш маш өндөр байгаа мөн иргэд олон нийт орчин цагт өдөр тутмын сонин хэвлэлээс илүүтэйгээр цахим системээр мэдээллийг авч байна.

- Үнэлгээний хороонд томилогдон ажиллаж байгаа хөндлөнгийн гишүүдийн урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийг сайжруулах:

- Үнэлгээний хороог байгуулахдаа системээс санамсаргүй байдлаар гишүүд томилогддог байх нь ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх, гомдол маргаан буурахад нөлөөлнө.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА

/У.БАЯРБИЛЭГ/

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
/П.УЯНГА/